



**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН
ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН ХЭРЭГЖИЛТЭД 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.07.07

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдэд бодит мэдээлэл өгөх, төрийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг Барилга, хот байгуулалтын сайдын /хуучин нэршлээр/ 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 112 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан үнэлж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан 9 зорилтын хүрээнд 19 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2025 оны 2 дугаар улирлын байдлаар **88.42** хувьтай, **“үр дүн гарсан”** гэж үнэлэв.

Үндсэн чиглэлд тусгагдсан нийт 19 арга хэмжээнээс 100 хувьтай 5 арга хэмжээ, 90 хувьтай 10 арга хэмжээ, 70 хувьтай 4 арга хэмжээ байна.

Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харуулбал:

№	Бодлогын зорилго, зорилт, арга хэмжээ	Зорилтот түвшин	Хэрэгжилт	хувь
Зорилго 2. Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.				
Зорилт 2.5. Эрүүл баталгаат орчныг бий болгоно:				
1	Арга хэмжээ 2.5.2 Орон сууц, ногоон	Өргөн мэдүүлсэн Хот байгуулалтын тухай хуулийн	1.“Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт”, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” /БНБД/-ын төслийг дуусгаж БХТ-өөс ШУТТЗХ-аар хэлэлцүүлэхээр 2024.06.17-ны өдрийн	90

	байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчилнэ.	шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан байна. -Хот, суурин газрын ногоон байгууламжийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна."Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/-ийг шинэчлэн батлуулсан байна.	2/1630 дугаартай албан бичгээр ирүүлснийг хянаж 2024.08.28-ны өдрийн 03/365 дугаар албан бичгээр "Олон нийт иргэний барилга" /БНБД/-тэй уялдуулан боловсруулахаар буцаасан.Олон нийт иргэний барилга" Инженерийн байгууламж, шугам сүлжээний орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2022.11.01-ний өдөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. ШУТТЗХ-аар хэлэлцүүлэх төслийг хүргүүлэх талаар гүйцэтгэгчтэй 2024.04.02-ны өдөр уулзаж чиглэл өгсөн. "Орон сууцны барилгын төлөвлөлт" /БНБД/, "Олон төрлийн зориулалттай барилга" /БНБД/-тэй уялдуулж боловсруулсан төслийг ШУТТЗХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлэхээр ажиллаж байна. 2.ХББОС-ын сайд, БОАЖ-ын сайд нарын хамтарсан 2025 оны 51/А/104 тоот тушаалаар Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн үзэл баримтлалын төсөл, анхдагч хуулийн төсөл, олон улсын ижил төстэй хуулийн судалгааг боловсруулсан. Уг хуулийн үзэл баримтлалын төсөл, анхдагч хуулийн төсөлд ажлын хэсгийн гишүүдээс саналыг авч тусган боловсруулж байна. 3.ХББОС-ын сайдын 2024 оны 79 дүгээр тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгаврыг ТНБД-ын 2024.11.01-ний 2024/07 дугаартай батлуулсан. "Хууль зүйн бичигт хүрээлэн" НҮҮТББ-тай 2024.12.02-ны өдрийн 2024/192 тоот гэрээ байгуулж хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, давхардал, хийдэл, зөрчлийн судалгаа, гадаадын улс орнуудын эрх зүйн зохицуулалтын тойм судалгаа, хуулийн үзэл баримтлалын анхдагч төсөл, танилцуулга зэргийг боловсруулан, 2025.02.19-ний өдөр дундын шатны тайланг хүлээлгэн өгсөн, хуулийн төсөл боловсруулж байна.Монголын хуульчдын холбоотой хамтран "Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлгийг 2025.04.25-нд зохион байгуулсан.	
2	Арга хэмжээ 2.5.3 Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.	"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичгийн УИХ-аар батлуулсан байна.	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж нийслэлийн Засаг дарга, ХББОС-ын сайд, ХЗДХ-ийн сайд, Сангийн сайд, МУ-ын сайд, 20 минутын хот үндэсний хорооны дарга нар 2024.12.31-ний өдөр хамтран баталсан. "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний баримт бичгийг 2025.01.08-ны өдөр ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 2-р тэмдэглэлээр УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу уг баримт бичгийг УИХ-ын ТББ-ын хорооны 2025.01.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон. УИХ-ын 2025.01.24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэж, ТББХ-нд шилжүүлсэн. УИХ-ын даргын 2025 оны 01 сарын 28-ний өдрийн 65 дугаар захирамжаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах	90

			үүрэг бүхий Ажлын хэсгийг УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнээр ахлуулан байгуулж ажиллаж байна. Энэ ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр ажиллах дэд ажлын хэсгийг ТББХ-ны ахлах зөвлөх Д.Хатантуулаар ахлуулан байгуулсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын дарга, ахлах шинжээч нар орж ажиллаж байна. Дэд ажлын хэсэг нь 2025.3.12, 4.01-нд, УИХ-ын гишүүн, ТББХ-ны дарга Ж.Бат-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг 2025.4.23, 2025.6.09-ний өдөр тус тус хуралдаж, төслийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэн ажиллаж байна.	
3	Арга хэмжээ 2.5.6 Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Архангай, Булган, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Сүхбаатар, Дорнод, Ховд аймгийн инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулсан байна. ЭЗХЯ-д үерийн хамгаалалтын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын санал хүргүүлсэн байна.	2021-2022 онд 13 байршилд зураг төсөл магадлалаар батлагдсан. 2021-2024 онд улсын төсвийн хөрөнгөөр нийслэлд 5, орон нутагт нийт 10 байршилд үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил хийгдэж ашиглалтад орсон. Хэнтий, Дархан -Уул аймгийн байршлын ажил төсөвт батлагдсан санхүүжилтийн дагуу үргэлжилж байна. 2025 оны хагас жилийн байдлаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XVIII.1.1.11, XVIII.1.1.22, XVIII.1.1.46-д тусгагдсан дараах үерийн хамгаалалтын барилга байгууламжийн бүтээн байгуулалтын ажил тус тус хэрэгжиж байна. Үүнд: • Дархан-Уул, Дархан сум, 1,2,3 дугаар баг-Хараа холын үерийн далан сувгийн шинэчлэлтийн ажилд “Хангилцаг” ХХК шалгарч 2025.05.29-ний өдөр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. /нийт 6.4 км -ээс 1.8 км-ийг 2025 онд шинэчилнэ/. • Хэнтий, Батноров суманд 2025 онд 497 сая төгрөгийн ажил улсын төсөвт тусгагдсан. Сонгон шалгаруулалтын түвшинд явагдаж байна. 2. МУ-ын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.1.4.1-д заасан, Тэргүүн Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайдын багцад туссан Сүхбаттар аймгийн ҮХББ-ийн зураг, төсвийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд Ажлын далагварын төслийг боловсруулж батлуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан. 3. "Шинэ Зуунмод" хотын эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээний ажил “Үерийн хамгаалалтын суваг-1 /6.2 км/”-ийн ажлыг хүрээнд Суваг-1.4, 1770м урттайгаас 1050м хийгдсэн 2025.06.15-ны байдлаар. 4. Нийслэлийн хэмжээнд МУЗГҮАХХАХТ-ийн 1.1.4.6-ийн 55-д тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн, Толгойт, Бэлх, Дунд голын эргийн хамгаалалтын 30 км далангаас байгуулахаар 13 км далан Туулын хурдын замын төслийн хүрээнд Туулын эргийн дагуу 3.9 км хийгдэхээр төлөвлөгдөж байна.	90
Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.				
Зорилт 3.2. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ:				
4	Арга хэмжээ 3.2.1 Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой	Ипотекийн 6 хувийн хүүтэй зээлийг өссөн дүнгээр 38476 иргэнд олгосон байна.	Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулинд “9.1.3.төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө	90

	иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь урьдчилгаа төлбөргүй, орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулдаг тогтолцоог бий болгоно.		нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” нэмэлт заалтыг тусгуулж батлуулсан.ЗГ-ын 2022 оны 301-р тогтоолоор Зээлийн батлан сангаар дамжуулан урьдчилгаа төлбөрийн 60 хүртэл хувь батлан гаргуулах буюу зээлийн урьдчилгаанд 12 хувийг төлөх боломж бүрдсэн. Монголбанкны Ерөнхийлөгчийн А-255 дугаар тушаал “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д “2.1.4 Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргасан тохиолдолд урьдчилгаа төлбөр 12 хувиас доошгүй, бусад тохиолдолд урьдчилгаа төлбөр 30 хувиас доошгүй” нэмэлт заалт орсноор ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах асуудлыг шийдвэрлүүлсэн. 2025.05.30-ны байдлаар орон нутагт 180 тэрбум төгрөгийг 1,559 зээлдэгч, мөн 362 зээлдэгч 42.1 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл авч, зээлийн батлан даалтын сангаар 111 зээлдэгч 2.33 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан. Ипотекийн 3 хувийн зээлийг нийт өссөн дүнгээр 4427 зээлдэгч 477 тэрбум төгрөгийн зээл авсан. “Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г ХББОС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай байгуулан 2025.03.20-ны өдөр эцэслэн баталсан. ЗГ-ын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар Уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны цэвэр ашгаас нийт 480.2 тэрбум төгрөгийг хуримтлалын сангаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн. 2025.05.30-ны өдрийн байдлаар нийт 521.9 тэрбум төгрөгийг 4,163 зээлдэгчид олгосноор өссөн дүнгээр 52187 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.	
5	Арга хэмжээ 3.2.2 Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхэлнэ.	Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг УИХ-р хэлэлцүүлсэн байна.	“Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийг Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци болгон зохион байгуулж, “Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр”-ийг ЗГ-ыг төлөөлж тус байгууллагад шилжүүлэх асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг Ерөнхий сайдын 2023.03.15-ны өдрийн 51-р захирамжаар байгуулагдсан. Ажлын хэсгээс боловсруулсан тогтоолын төслийг 2023.12.27-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан “Иргэдийг орон сууцжуулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 483 дугаар тогтоол гаргасан. Уг тогтоолд “Үндэсний орон сууцны санхүүжилтийн корпорацийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх” гэж заасны дагуу Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хэсгийг БХБЯ-ны ТНБД-ын 2024.04.30-ны өдрийн А/50 дугаар тушаалаар байгуулж, үзэл баримтлалыг БХБСайд, СаСайд, ХЗДХСайд нараар батлуулсан. Хуулийн төсөл, түүний хэрэгцээ шаардлагын тандан	70

			судалгаа, үзэл баримтлал, зардлын тооцоо, үр нөлөөний үнэлгээ, дагах хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын 2024.5.08-ны өдрийн хуралдаанаар дэмжигдэж, УИХ-ын ЭЗБХ-оор 2024.5.28-ны өдөр хэлэлцэн дэмжигдэж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар УИХ-ын 2024.5.30-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэн дэмжигдсэн ч УИХ-ын ээлжит сонгууль болж хуулийн төслийг ЗГ-т буцаасан. Засгийн газрын 2024.8.14-ний өдрийн хуралдаанаар “Орон сууцжуулалтын талаар 2024-2028 онд баримтлах бодлого, чиглэл”-ийг танилцуулсан. Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлүүлсэнтэй холбоотойгоор ХББОССайдын 2024.12.02-ны өдрийн 107 дугаар тушаалаар Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ авахаар 2024.11.25-ны өдрийн 2024/159 дугаартай хамтран ажиллах гэрээг “Легал инновешн хаав” ХХК-тай байгуулан ажиллаж байна.	
6	Арга хэмжээ 3.2.3 Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бий болгоно.	Төрийн түрээсийн орон сууцны тоог нэмэгдүүлэх хүрээнд "Ногоон нуур 1008 айлын орон сууц", "Солонго 1,2" орон сууцны төслийг эрчимжүүлсэн байна.	Хятад улсын буцалтгүй тусламжаар гэр хорооллын дахин төлөвлөлтийн "Ногоон нуур 1008" орон сууцны төсөл 2025 оны 7 дугаар сард урьдчилсан техникийн комисс ажиллуулах төлөвлөгөөтэй барилга угсралтын ажил үргэлжилж байна. "Солонго-1, 2" 5002 айлын орон сууцны төслийн эхний ээлжийн 980 айлын орон сууцны барилгыг 2025 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй барилга угсралтын ажил хэвийн үргэлжилж байна. 980 айлын орон сууцны барилгын ажил 80 хувьтай байна. ХББОССайдын 2024.12.02-ны өдрийн 107 дугаар тушаалаар Орон сууцжуулалтын тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Хуулийн төсөлд зөвлөх үйлчилгээ авахаар 2024.11.25-ны өдрийн 2024/159 дугаартай хамтран ажиллах гэрээг “Легал инновешн хаав” ХХК-тай байгуулан Ажлын хэсгийн хурлаар хуулийн хэрэгцээ шаардлагын судалгаа, тандан судалгааны тайланг хэлэлцэж дүгнэлт өгсөн. Үндэсний орон сууцжуулалтын хуулийн үзэл баримтлалын батлуулах төслийг ГБХНХЯ болон Сангийн яам руу 2025.02.14-ний өдрийн 01/551; 01/552 дугаартай албан бичгээр хүргүүлснээс Сангийн яамнаас баталгаажуулах саналыг ирүүлсэн бөгөөд Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хариу хүлээгдэж байна. Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн төслийг 2025.02.26-ний өдөр зөвлөх үйлчилгээний компаниас ирүүлж, иргэд, олон нийтийн санал авахаар 2025.02 .27-ны өдөр яамны https://mcud.gov.mn/forum/42 цахим хаягт байршуулан иргэд олон нийтээс санал авч байна. Тус хуулийн төслийг 2025.3.10 -ны өдөр Барилгын үндэсний ассоциаци ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүд болон гишүүдэд, 2025.4.18 -ны өдөр аймаг нийслэлийн ерөнхий архитекторуудад танилцуулан хэлэлцүүлсэн.	90
7	Арга хэмжээ 3.2.4 Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг	Шохойн үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна.	Шинээр хэрэгжих төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх, хамтран ажиллах саналыг ЭЗХЯ УУХҮЯ, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад хандсан.	70

	үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.	1. Цемент үйлдвэрлэл: Баруун бүст Вестерн Холд ХХК-ийн цементийн үйлдвэрийн төслийг дэмжиж Ховд аймагт 350 мянган тонн/жил хүчин чадалтай үйлдвэр 2021 онд ашиглалтад орсон. 2. Шилний үйлдвэрлэл: Эрдэс плазм ХХК-ийн төслийг дэмжин Хөгжлийн банканд 2020.02.11-ний өдрийн 01/01/537, 2022.10.06-ны өдрийн 3/4622 тоот албан бичгээр санхүүжилтын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хариу хүссэн албан бичгийг хүргүүлсэн. 3.Гангийн үйлдвэрлэл: Эрдэнэтийн “Бэрэн групп” ХХК-ийн гангийн үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтийг Дэлхийн банк, Хөгжлийн банкинд 2020-2021 онд удаа дараа хүргүүлсэн боловч тус компаний өмнө авсан чанаргүй зээлээс шалтгаалан санхүүжилт шийдэгдээгүй. “Бэрэн групп” ХХК-ийн гангийн үйлдвэрийн төслийг дэмжин 2021-2022 онд Эрдэнэт үйлдвэр, УУХҮЯ, ЭЗХЯ-нд хамтран ажиллахыг хүссэн санал хүргүүлсэн. 4.Шохойн үйлдвэрлэл: “Цэн газар” ХХК-ийн Говь-Алтай аймгийн Тайшир суманд байгуулах цемент, шохойн үйлдвэрийн төслийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх асуудлыг ЗГ-ын 2024.01.25-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж ЗГ-ын 37-р тогтоол гарсан. 5.Эх орны эрдэс түүхий эд, түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудал боловсруулж, Бүсчилсэн хөгжлийн өргөтгөсөн хуралдаанд Хангайн бүст 2025.04.14-нд, Хойд бүст 2025.04.28-нд, Говийн бүст 2025.05.12-нд танилцуулсан. Мөн Төвийн бүсийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төсөлд уг асуудлыг тусгуулах санал өгсөн. 6.Хөтөлийн болон Налайхын БМҮТП-ын орчинд ажиллах үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг ХББОСЯ-ны дэргэдэх “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн мэргэжлийн зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах чиглэлийг “Эрдэнэс ҮТП” ХХК, Налайхын Үйлдвэрлэл технологийн парк” ХК-д 2025.06.02-ны өдрийн 03/2182 бичиг хүргүүлсэн.		
Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга нэмэгдэж, ядуурал буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, нефть, шатахууны дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн улс болно.				
Зорилт 4.2 Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ:				
8	Арга хэмжээ 4.2.7 Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээ-15 км, бохир усны шугам -20 км, дулааны шугам сүлжээ-8 км, цахилгааны шугам-5км	Дархан-Уул аймгийн “Залуус 2” хорооллын гадна ус хангамжийн 3,35 км, 2,11 км шугам хоолойн ажлыг 2024.10.30-нд ашиглалтад оруулсан. "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн хүрээнд 9.2 км ус хангамжийн шугамын угсралт хийгдсэн.Говь-Алтай аймагт "Цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл" ажлын хүрээнд 1.5 км урт шугамын ажил 2024.10.10-ны өдөр ГАА-КД-08/2024, Баян-Өлгий аймгийн Өлгий суманд "Гэр хорооллын усан хангамжийн шугам сүлжээ" ажлын хүрээнд 1.38 км ус хангамжийн шугам сүлжээг гүйцэтгэж, 2024.10.03-ны ББКД-83 05/24 ашиглалтад оруулсан. Залуус-1 " орон сууцны хорооллын гадна цахилгаан хангамжийн	90

			угсралтын ажил 110кВа-ын Цахилгаан дамжуулах агаарын шугам 6,2км хийгдсэн.УБ хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийн Шувуун фабрик эх үүсвэрийн ус цуглуулах 7 км, ус дамжуулах 15,5 км шугам угсрагдсан.Чингис хотын гэр хорооллын инженерийн шугам сүлжээ багц-2 ажлын хүрээнд 9.6 км ариутгах татуургын шугам сүлжээ хийгдсэн. Орхон, Баян-Өндөр сумын "Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй ариутгах татуургын 3-р коллекторын төв шугам татах ажил"-ын хүрээнд 7.6км ариутгах татуургын шугам хийгдсэн. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажил- Хөндий 35кВ ЦДАШ, 35/10кВ-ын 2х10000кВА чадалтай Хөндий дэд станц, 110/35/10кВ-ын дэд станцын өргөтгөл/Төв/,нийт 105 ширхэг анкер цахилгаан дамжуулах агаарын шугам 15,7км хийгдэж комисс ажиллахад бэлэн болсон. Мөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ /гүний худаг, 16 км салбар шугам/-ний гүйцэтгэгч "Эс Энд Трейд" ХХК ус хангамжийн 2 дамжуулах Ф280х25.4 мм-ийн голчтой 3,756 км шугам, Эдийн засгийн чөлөөт бүсээс 1-15 худаг хүртлэх 2,69 км шугам, гол шугамын 1-р хэсгийн 4,83 км шугамын ажлыг гүйцэтгэж, 2024.12.06-нд улсын комисс ажилласан. Нийтдээ 2021-2025 онд цэвэр усны 187.32 км, бохир усны 68.15 км, дулааны 53.3 км, цахилгааны 96.8 км шугам сүлжээний БУА гүйцэтгэсэн. Үүнээс цэвэр усны 69.3 км, бохир усны 8.8 км, дулааны 8.5 км, цахилгааны 3.8 км шугамын ажил бүрэн хэрэгжсэн	
Зорилго 8. Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагалт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, өрсөлдөх чадвартай, харьцангуй тэнцвэртэйгээр бүс, орон нутгийг хөгжүүлнэ.				
Зорилт 8.1. Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно:				
9	Арга хэмжээ 8.1.5 Чөлөөт бүс, хилийн боомтуудын барилга байгууламж, тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, олон улсын стандартад нийцүүлэн, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.	"Алтанбулаг" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. "Замын-Үүд" чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан байна. Замын-Үүд, Алтанбулаг боомтод барилгын материалын импортын хангамж төв байгуулах ТЭЗҮ боловсруулсан байна.	Замын-Үүд-Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийн боловсруулах зургийн даалгаврыг Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн албатай хамтран боловсруулж, МУ-ын Шадар сайдболон ХББОС-ын сайд нараар хамтран баталсан. Цагааннуур чөлөөт бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг тус яамны захиалгаар 2022-2024 онд "Инженер геодези" ХХК боловсруулж, Засгийн газрын 2025 оны 09 дүгээр тогтоолоор баталсан. Чөлөөт бүсийн эхний ээлжийн цахилгаан, холбоо, дулаан, цэвэр бохир усны хангамж зэрэг дэд бүтцийн хангамжийн зураг төслийг 2024 онд "Гидродизайн прожект" ХХК боловсруулсан. Мөн эхний ээлжийн (2025-2028 онд хэрэгжүүлэх) хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөл, Тээвэр логистикийн ТЭЗҮ, судалгаа болон нарийвчилсан зураг төсөл, инженерийн дэд бүтцийн хангамж бүтээн байгуулалтын ажил, засаг, захиргааны болон мэргэжлийн албадын барилгын ажил, 1 дүгээр зэрэглэлийн 14.8 км авто замыг барих зэрэг ажлуудын хөрөнгө оруулалтын зардлын тооцооллыг гаргасан. Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2025 оны 10 дугаар тогтоолоор баталсан. Алтанбулаг чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврыг батлуулсан. Сэлэнгэ аймгийн	90

			Алтанбулаг хилийн боомтод байрлалтай Хими, будгийн лабораторийн тоног төхөөрөмжийг 2025 суурилуулан хүлээн авч, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөхөөр ТНБД-ын 2024.12.11-ний өдрийн Б/98 дугаартай ажлын хэсэг байгуулагдан бэлтгэл ажлыг хангаж байна. Дорноговь аймгийн Замын-Үүд хилийн боомтод Барилгын материалын сорилт, шинжилгээний түргэвчилсэн лабораторийг барьж байгуулсан бөгөөд 2025 оны эхний ээлжинд нийлүүлэгдэх /керамик эдлэхүүн, цемент, цонх, хаалга, хуванцар болон цхаилгаан утас/ лабораторийн иж бүрэн тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2024.12.11-ний өдрийн Б/98 дугаараар байгуулж 2025.6.05-07-ны өдрүүдэд ажиллаж тоног төхөөрөмжийг хүлээн авсан.	
10	Арга хэмжээ 8.1.8 Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжинд алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.	УИХ-р батлагдсан Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	АХБ-ны техник, туслалцаагаар Хүн амын нутагшилт, суурьшлын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Увс, Ховд, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь, Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий, Төв, Дундговь, Говьсүмбэр, Улаанбаатар хотын хөгжлийн чиг баримжаа судалгааг боловсруулсан. “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн үндсэн хэрэгжүүлэгч нь ЭЗХЯ бөгөөд ХББОСЯ нь хамтран хэрэгжүүлэгчээр оролцож байна. Тус хөтөлбөр нь хөдөө аж ахуйн салбарт оруулах ногоон санхүүжилтийг дэмжих, бэлчээрийн менежментийг сайжруулан, хянах тогтолцоог бүрдүүлнэ. Хөтөлбөрийн I үе шатанд Баян-Өлгий, Увс, Ховд аймгууд хамрагдахаар төлөвлөгдсөн. Эдгээр аймгуудад 2024 оны 12 сард ЭЗХЯ болон ХББОСЯ бусад холбогдох байгууллагуудын хамтарсан баг газар дээр нь ажилласан. Аймаг, сумдын ногоон бүс нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих Увс аймгийн Өмнөговь сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын төсөлд 2025 оны 05/883 дугаартай албан бичгээр санал өгч, ЗТ-15/2025 дугаартай зургийн даалгаврыг Увс аймгийн Засаг дарга баталсан. Хүн амын нутагшил суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо, төлөвлөлтийн шийдлүүдийг харилцан уялдуулан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан.	70
11	Арга хэмжээ 8.1.10 Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	5 сумын төвд инженерийн шугам сүлжээ шинээр барьж ашиглалтад оруулна.	Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл арга хэмжээг 2021.6.01-ний өдрийн 161 дүгээр тогтоолоор батлуулсан. 1. Өвөрхангай, Хужирт сум улсын комисс ажиллаж хүлээн авсан.2. Төв, Борнуур сумын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил дуусч, улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. 3. Төв аймгийн Дэлгэрхаан сумын инженерийн шугам сүлжээний ажлаас гадна ариутгах татуурга, гадна цахилгаан хангамжийн шугамын ажил дуусч улсын комисс ажиллаж хүлээн авсан.4. Төв аймгийн Сэргэлэн сумын инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэн улсын комисс ажиллаж хүлээн авсан. 5.Төв аймгийн Эрдэнэ сумын инженерийн шугам сүлжээний 2024 оны ажлыг гүйцэтгэн инженерийн шугам сүлжээний ажлыг улсын комисс ажилласан. 6. Төв аймгийн Баянчандмань сумын цэвэр усны эх	70

			үүсвэрийн 1150 м шугам хоолойн угсралтын ажил дууссан. Цэвэр усны 2 худгийн ажлыг гүйцэтгэсэн. 2 ширхэг усан сангийн ажил 90 хувьтай, нийт гүйцэтгэл 90 хувь байна. Хугацаандаа хэрэгжиж байна. 7. Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын төвийн гадна ариутгах татуургын PVC-U Ф160-200мм-ийн 2152 метр, "Аварга тосон" рашаан сувиллын газрын гадна ариутгах татуургын PVC-U Ф160-Ф200мм 3030 метр 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын 3,757 метр шугам, 100кВА-ын дэд өртөөний ажил, "Аварга тосон" рашаан сувиллын газрын 50м3/хон хүчин чадалтай бохир усны цооногийн ажлыг гүйцэтгэж дууссан. Сумын төвийн 100м3/хон хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж гүйцэтгэн улсын комисс ажилласан. Нийтдээ 19 суманд төсөл хэрэгжсэнээс цэвэр усны 21.38 км, бохир усны 13.6 км, дулааны 12.8 км, гүний худаг-6ком, цэвэрлэх байгууламж 19 ком, ашиглалтад орсон байна. Дорнод аймгийн Дашбалбар сум, Өвөрхангай аймгийн Хужирт сум, Ховд аймгийн Булган сум, Хэнтий аймгийн Галшар сумын төслүүд бүрэн хэрэгжиж дууссан ба бусад 15 аймагт хэрэгжилтийн шатанд 50-98% байна. Нийт хэрэгжилт 80,9%.	
Зорилго 9. Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлнэ.				
Зорилт 9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.				
12	Арга хэмжээ 9.2.3 Ногоон барилгын стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.	Судалгаанд үндэслэн ногоон барилгын тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.	1. "Ногоон барилга"-ын үнэлгээ хийх эрх бүхий аудитор бэлтгэх ажлын хүрээнд холбогдох баримт бичгийн мэдлэг олгох сургалт семинарыг 2025.3.21-ний өдөр зохион байгуулж "Ногоон барилгын үнэлгээний аргачлалыг норм, нормативын баримт бичигтэй уялдуулах нь" сэдвээр "Сургалт, судалгаа мэдээллийн хэлтэс"-тэй хамтран сургалт зохион байгуулсан. 2. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.02-ны өдрийн 108-р тушаалаар "Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал", Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.27-ны өдрийн 153 дугаар тушаалаар "Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам", Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.5.16-ны өдрийн 114 дүгээр тушаалаар "Ногоон барилгын аудитор, сургагч багш бэлтгэх журам" тус тус баталсан. 3. "BestGER" Ногоон барилгын Хялбаршуулсан төрөлд аудитор эрх олгох сургалтад хамрагдсан 53 ИТА-ыг 2025.6.09-ний өдрөөс 2025.6.15-ны өдрүүдэд 2 үе шаттай шалгалт авах үйл ажиллагааг зохион байгуулж 2025.6.27-ны өдөр "BestGER" Ногоон барилгын Хялбаршуулсан төрөлд аудитор хийх шаардлагыг хангаж шалгалтад тэнцсэн 11 аудиторт гэрчилгээ гардуулсан. 4. "Гамшигт тэсвэртэй, эрчим хүчний алдагдал багатай, дэвшилтэт технологи бүхий "Амины орон сууц"-ны загвар төсөл хэрэгжүүлэхээр 2023.04.28-ны өдрийн 518/2023 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажсан, барилгын эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээтэй Гамшигт тэсвэртэй "Амины орон сууцны 40 м2, 60 м2, 80м2, 100 м2, 120 м2" бүхий нэг маягийн зураг төсөлд ногоон барилгын үнэлгээ хийж, эрчим хүчний хэмнэлтийн ангиллыг нэмэгдүүлэн "Амины орон сууцны загвар төсөл"-ийг Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэгт хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж, "Монголын ногоон	100

			барилгын хүрээлэн" НҮТББ гүйцэтгэгчээр шалгарч, гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. "Амины орон сууцны /60 м2/ нэг маягийн зураг төсөл"-ийг холбож, холболтын зураг төслийг боловсруулж дуусган магадлалаар хянуулж байна.Төслийн талбайг бэлтгэж барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл хангаж байна	
Зорилт 9.3. Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ:				
13	Арга хэмжээ 9.3.3 Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлнэ.	Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам -3 км, дулааны шугам сүлжээ-5 км	2021 онд: цэвэр усны 78,1км, бохир усны 12,6 км, дулаан хангамжийн 1,1 км, цахилгааны 0,8км, үерийн хамгаалалтын 8км, гэрэлтүүлгийн 235км. 2022 онд: цэвэр усны 56,64км, бохир усны 44,76км, дулааны 32,15км, цахилгааны 1,93км, 2023 онд: цэвэр ус -9.4км бохир ус-7.76км, дулаан-3.8 км, цахилгаан 5.3км, 2024 онд: цэвэр ус 45.296 км, 5000 ш ухаалаг тоолуур, бохир ус -48.48км, дулаан 34,41км, цэвэрлэх байгууламж-2ком. Нийт цэвэр ус 189.44 км, бохир ус -113.6км, дулаан 71.46км, цахилгаан 20.3 км шугам сүлжээний БУА гүйцэтгэсэн. Үүнээс цэвэр ус 71.6 км, бохир ус -14.5 км, дулаан 11.6 км, цахилгаан 0.8 км шугам сүлжээний ажил, гэрэлтүүлгийн 235 ажил бүрэн хэрэгжсэн. "Дархан хотын цэвэр усны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх, ухаалаг тоолуур нэвтрүүлэх төсөл"-ийн хүрээнд ус хангамжийн 9,2 км шугам сүлжээг суурилуулж, 5000 ш ухаалаг тоолуур суурилуулах ажлыг гүйцэтгэсэн. 2025 он: Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/ нь 2025 оноос хэрэгжиж байгаа бөгөөд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.01.22-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 20 дугаар тушаалаар 29 төсөл, арга хэмжээ баталсан. Үүнээс 169,986.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 42,233.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 22 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгарч, 43,213.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10,726.0 сая төгрөгийг санхүүжих дүнтэй 7 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч шалгараагүй байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар гүйцэтгэлийн санхүүжилт хараахан гараагүй байна.	90
Зорилт 9.4. Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ:				
14	Арга хэмжээ 9.4.1 Хотын засаглалын оновчтой тогтолцоог бүрдүүлэн бүх шатны төлөвлөлт, төлөвлөгөөг боловсруулах, батлах, шийдвэр гаргахад иргэд, олон нийтийн оролцоог хангаж, иргэдийн мэдээлэл олж авах сувгийг нээлттэй,	Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулсан байна.	1.Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний баримт бичиг, УИХ-ын тогтоолын төсөлд https://d.parliament.mn/сайтаар дамжуулан 2025.01.07-ны өдрөөс эхлэн олон нийтийн саналыг авч тусгасан. 2."Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ыг мөрдүүлж,зураг төслийн баримт бичигт экспертиз хийх шатанд хянан хэрэгжилтийг хангуулсан. ХББОС-ын сайдын 2025 оны 7 тушаалаар 10 хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, 7 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд экспертиз хийж байна. 3.Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтэд танилцуулах, санал авсан. 2025 оны 4-р сард ААН болон иргэд олон нийттэй 6 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Мөн Баруун-Урт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг	100

	хүртээмжтэй, ил тод болгоно.		иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах ажлыг 2024 оны 11-р сард зохион байгуулсан. 4.Булган аймгийн Могод, Бүрэгхангай, Сэлэнгэ сумын төвийн ХЕТ-ний тодотгол, Орхон сумын Халиун 2-р баг, Мааньт 4-р багуудын суурьшлын бүсийн хэсэгчилсэн ХЕТ, Ховд аймаг, Жаргалант сум, 5, 12-р баг, 4, 5, 11, 12-р гэр хорооллын бүс, 1, 4, 5, 7, 12-р багуудын холимог бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Увс аймгийн Түргэн, Зүүнхангай, Наранбулаг, Тариалан, Өмнөговь сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Төв аймгийн Сэргэлэн, Баянжаргалан сумын төвийн ХЕТ-ний тодотгол, Баян-Өлгий аймгийн Өлгий хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг боловсруулах зургийн даалгаварт холбогдох хууль, журмын дагуу иргэдээс санал авах, хэлэлцүүлэх шаардлагыг тусгаж батлуулсан. 5. Сайдын 2024 оны 79-р тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг ХББОСС-ын 2024 оны 79 дүгээр тушаалаар Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж “Хууль зүйн бичигт хүрээлэн” НҮҮТББ-тай Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж, ажлыг эхлүүлсэн.	
15	Арга хэмжээ 9.4.3 Дархан, Эрдэнэт болон бусад том хотуудыг улсын зэрэглэлтэй болгож, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ.	Дархан, Эрдэнэт хотуудын зэрэглэл тогтоогдсон байна.	Хот тосгон эрх зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсантай холбогдуулан УИХ-ын 2024 оны 72-р тогтоолоор улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн зэрэглэлтэй 43, дагуул 4 хот байгуулахаар шийдвэрлэсэн. ЭЗХЯ, Орхон аймгийн ЗДТГ болон “Нью-Урбанизм” ХХК -ийн хооронд 2024.12.06-ны өдөр байгуулсан УТ2406600094021/ЭЗХЯ202451 дугаартай гэрээний дагуу “Бүсийн тулгуур төв, Орхон аймгийн Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” /Орхон аймаг, Баян-Өндөр сум/-г боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж дэмжлэг, зохицуулалтаар хангах болон санал, зөвлөмж өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/43 тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хурлыг 2025.3.25-ны өдөр зохион байгуулж, гүйцэтгэгч “Нью Урбанизм” ХХК-ийн боловсруулсан ерөнхий төлөвлөгөөний баримт бичгийн төслийг хэлэлцэж, холбогдох үүрэг даалгаврыг өгч ажиллаж байна. “Нью Урбанизм” ХХК-иас эхлэлийн тайланг Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т 2025.4.23-ны өдөр, ажлын гүйцэтгэлийг 2025.5.14-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн.	100
Зорилт 9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ:				
16	Арга хэмжээ 9.5.1 Олон төвт хотын тогтолцоог хэрэгжүүлж, “Шинэ Зуунмод”,	“Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц” төслийг үргэлжлүүлэн	“Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж ЗГ-ын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан. Уг ерөнхий төлөвлөгөөний дагуу дараах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, холбогдох зураг төслийг боловсруулж, батлуулсан. “Шинэ Зуунмод хот”-ын эхний ээлжийн	100

	“Майдар” шинэ дагуул хотын бүтээн байгуулалтыг эхлүүлж, инженерийн шугам сүлжээ, орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлсэн байна.	хэрэгжүүлнэ. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн үлдэгдэл ажил болох инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг 30 хувь гүйцэтгэсэн байна. /төсөвт тусгагдсан тохиолдолд эхлүүлэх/	суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө “Сургалт-Эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө Дулаан хангамжийн зураг төсөл, төсөв Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсөв Ариутгах татуургын шугам, насосны станцын барилгын ажлын зураг төсөл, төсөв “Богд хаан” төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, ТЭЗҮ, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах ажил; Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилчдын 600 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв; Эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлын хүрээнд цахилгаан хангамжийн ажил (“Хөндий” дэд станц, “Зуунмод” дэд станцын өргөтгөл, цахилгаан дамжуулах 15.7 км агаарын шугам), үерийн далан хамгаалалтын суваг (4.9 км), ус хангамж ажил (гадна усан хангамж 14 км, гүний худаг 5 ш, өргөлтийн насос станц 1 ш)-ыг хийж, 2024 онд ашиглалтад оруулсан. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар 2025.01.25-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан. ЗГ-ын 2024 оны 59-р тогтоолоор Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхт төлөөлөгчийг, 2024 оны 67-р тогтоолоор Хүннү хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар баталсан. ЗГ-ын 2024 оны 114-р тогтоолоор Хүннү хотын хөгжлийн корпорац ХХК-г байгуулах шийдвэр гарч 2025 оны 3р сараас “Хотын газар хөгжүүлэлт, менежмент, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, нийслэлийн 80%, Төв аймгийн 20%-ийн өмчийн оролцоотой “Хүннү хотын хөгжлийн корпорац” ХХК байгуулагдан ажиллаж байна.	
17	Арга хэмжээ 9.5.2 Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.	Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хүрээнд Төв аймгийн Сэргэлэн суманд нисэх онгоцны буудлыг түшиглэн бий болох Логистикийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна.	"Олон улсын нисэх онгоцны "Чингис Хаан" буудлыг түшиглэн бий болох "Богд Хаан төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр, логикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн хангамжийн судалгаа, эх үүсвэр тодорхойлох" судалгааны ажилд 2022 онд магадлалын дүгнэлт гарч, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө Төв аймгийн ИТХ-ын 2023 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан.	100
18	Арга хэмжээ 9.5.4 Дагуул хотуудад	Налайхын УТП-ын 26 мегаваттын Дулааны станц,	1. “Бүтээн байгуулалтын зарим төслийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Налайхын болон Хөтөлийн “Барилгын	90

	дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	Цэвэрлэх байгууламжийн төсвийг 2025 оны улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн байна.	материалын парк"-ын бүтэц, төрийн өмчийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамыг тогтоох заалт оруулах саналыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад 2024.10.01-ний өдрийн 01/703 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2. БХБ-ын сайдын НЗД-тай байгуулах гэрээнд Налайхын БМҮТП-ын чиглэлээр хамтран ажиллах талаар тусгасан. Нийслэлийн төсөвт энэ онд 16.2 тэрбум төгрөг тусгаж, 2*16 мегаватт цахилгаан хангамжийг байгуулснаар тус паркад орж ажиллахаар 12 аж ахуйн нэгж Паркын захиргаатай гэрээ байгуулж, барилгын ажлаа гүйцэтгэж байна. Багануур үйлдвэр технологийн паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76км өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтын үлдэгдэл 2025 онд санхүүжих 300.0 сая төгрөгийн эрхийг НЗД-ын 2025.02.13-ны өдрийн А/197 дугаар захирамжийн дагуу НХЛГ-т шилжүүлсэн. НХОГ-ын 2025 оны А/21 дугаар тушаалын дагуу 2025.03.14-ний өдөр Паркийн үндсэн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76км цахилгаан дамжуулах агаарын шугамыг ашиглалтад оруулахаар техникийн комисс ажилласан. Налайхын "БМҮТП"-ын 1000 м3 цэвэрлэх байгууламжийг барих ажилд шаардагдах 5,325.9 сая төгрөгийг 2026 оны улсын төсвийн тухай хуульд тусгуулах саналыг хүргүүлсэн. Багахангайн үйлдвэрлэл технологийн паркийн албан конторын барилгын зураг төслийг боловсруулах тендерийг 40,000,000 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр 2025 онд НХААГ-аас тендер зарлаж "Арткон" ХХК шалгарч гэрээ байгуулсан.	
19	Арга хэмжээ 9.5.6 цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.	Хөшгийн хөндийн чөлөөт бүсийн эхний ээлжийн инженерийн шугам сүлжээний зураг төслийг боловсруулсан байна. Богдхан Уулын Номт амны ерөнхий төлөвлөгөө, "Шинэ Зуунмод" хотын төв, засаг захиргааны бүсийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан байна. Хөшигийн хөндийн шинэ хотын инженерийн дэд бүтэц төслийг барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж хийсэн байна.	"Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж ЗГ-ын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан. Уг ерөнхий төлөвлөгөөний дагуу дараах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, холбогдох зураг төслийг боловсруулж, батлуулсан. "Шинэ Зуунмод хот"-ын эхний ээлжийн суурьшлын бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө "Сургалт-Эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор"-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө Дулаан хангамжийн зураг төсөл, төсөв Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсөв Ариутгах татуургын шугам, насосны станцын барилгын ажлын зураг төсөл, төсөв "Богд хаан" төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логистикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, ТЭЗҮ, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах ажил; Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилчдын 600 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв; Эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлын хүрээнд цахилгаан хангамжийн ажил ("Хөндий" дэд станц, "Зуунмод" дэд станцын өргөтгөл, цахилгаан дамжуулах 15.7 км агаарын шугам), үерийн далан хамгаалалтын суваг (4.9 км), ус хангамж ажил (гадна усан хангамж 14 км, гүний худаг 5 ш, өргөлтийн насос станц 1 ш)-ыг хийж, 2024 онд ашиглалтад оруулсан. Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар 2025.01.25-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан. ЗГ-ын	90



		/төсөвт тусгагдсан тохиолдолд/	2024 оны 59-р тогтоолоор Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхт төлөөлөгчийг, 2024 оны 67-р тогтоолоор Хүннү хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар баталсан. ЗГ-ын 2024 оны 114-р тогтоолоор Хүннү хотын хөгжлийн корпорац ХХК-г байгуулах шийдвэр гарч 2025 оны 3р сараас “Хотын газар хөгжүүлэлт, менежмент, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, нийслэлийн 80%, Төв аймгийн 20%-ийн өмчийн оролцоотой “Хүннү хотын хөгжлийн корпорац” ХХК байгуулагдан ажиллаж байна.	
Үндсэн чиглэлийн хэрэгжилт				88.4

Дараах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

“Шинэ Хархорум” хотыг байгуулах 189363 га газрыг ЗГ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор тогтоож тусгай хэрэгцээнд авсан. Хотыг байгуулах ажлын хүрээнд холбогдох нийт 16 ажлын даалгавар батлагдаж Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг Засгийн газрын 2025.04.09-ний өдрийн 165 дугаар тогтоолоор баталсан. Ерөнхий төлөвлөгөөний даалгаврыг боловсруулж батлуулсан.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төсөлд ХАНСХЕТ-ийг боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн судалгаа, тооцоо, төлөвлөлтийн шийдлүүдийг харилцан уялдуулалан “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” УИХ-ын 2024.06.05-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан.

“Хот байгуулах тухай” УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор улсын зэрэглэлтэй 6, орон нутгийн зэрэглэлтэй 43, дагуул 4 хот байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд үндсэн чиглэлд тусгагдсан Дархан, Эрдэнэт зэрэг хотуудыг улсын зэрэглэлтэй хот болгон тогтоосон.

Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн чиглэлээр 2021-2022 онд 13 байршилд зураг төсөл болон Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө батлагдсан бөгөөд 2021-2025 онуудад улсын төсвийн хөрөнгөөр нийслэлд 5, орон нутагт нийт 10 байршилд үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажил хийгдэж ашиглалтад орсон байна.

Ногоон барилгын тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”, “Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам”, “Ногоон барилгын аудитор, сургагч багш бэлтгэх журам” тус тус баталсан. “BestGER” Ногоон барилгын Хялбаршуулсан төрөлд аудитор эрх олгох сургалтад хамрагдсан аудитор хийх шаардлагыг хангаж шалгалтад тэнцсэн 11 аудиторт гэрчилгээ гардуулсан.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулинд өөрчлөлт оруулж ЗГ-ын 2022 оны 301-р тогтоолоор Зээлийн батлан сангаар дамжуулан урьдчилгаа төлбөрийн 60 хүртэл хувь батлан гаргуулах буюу зээлийн урьдчилгаанд 12 хувийг төлөх боломж бүрдсэн. Монголбанкны Ерөнхийлөгчийн А-255 дугаар тушаал “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д “2.1.4 Зээлийн батлан даалтын сангаас батлан даалт гаргасан тохиолдолд урьдчилгаа төлбөр 12 хувиас доошгүй, бусад тохиолдолд урьдчилгаа төлбөр 30 хувиас доошгүй” нэмэлт заалт орсноор ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийг бууруулах асуудлыг шийдвэрлүүлсэн.

Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд 2025.05.30-ны байдлаар орон нутагт 180 тэрбум төгрөгийг 1,559 зээлдэгч, мөн 362 зээлдэгч 42.1 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл авч, зээлийн батлан



даалтын сангаар 111 зээлдэгч 2.33 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан. Ипотекийн 3 хувийн зээлийг нийт өссөн дүнгээр 4427 зээлдэгч 477 тэрбум төгрөгийн зээл авсан. Нийт 521.9 тэрбум төгрөгийг 4,163 зээлдэгчид олгосноор өссөн дүнгээр 52187 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.

“Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г ХББОС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай байгуулан 2025.03.20-ны өдөр эцэслэн баталсан. ЗГ-ын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар Уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны цэвэр ашгаас нийт 480.2 тэрбум төгрөгийг хуримтлалын сангаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна.

Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд нийт цэвэр усны 189.44 км, бохир усны 113.6 км, дулаан хангамжийн 71.46 км, цахилгаан хангамжийн 20.3 км шугам сүлжээг барьж байгуулсан байна.

Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулах ажлын хүрээнд “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж ЗГ-ын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан. Уг ерөнхий төлөвлөгөөний дагуу “Шинэ Зуунмод хот”-ын эхний ээлжийн суурьшлын бүс, “Сургалт-Эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн цогцолбор”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, дулаан хангамжийн зураг төсөл, төсөв, Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсөв, Ариутгах татуургын шугам, насосны станцын барилгын ажлын зураг төсөл, төсөв, “Богд хаан” төмөр зам, авто замын зангилаа бүхий олон улсын тээвэр логикийн нэгдсэн төвийн инженерийн дэд бүтцийн судалгаа, ТЭЗҮ, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах ажил, Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилчдын 600 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв боловсруулж батлуулсан.

Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлын хүрээнд цахилгаан хангамжийн ажил (“Хөндий” дэд станц, “Зуунмод” дэд станцын өргөтгөл, цахилгаан дамжуулах 15.7 км агаарын шугам), үерийн далан хамгаалалтын суваг (4.9 км), ус хангамж ажил (гадна усан хангамж 14 км, гүний худаг 5 ш, өргөлтийн насос станц 1 ш)-ыг хийж, 2024 онд ашиглалтад оруулсан.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, УИХ-ын нэгдсэн чуулганаар 2025.01.25-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан. ЗГ-ын 2024 оны 59-р тогтоолоор Хүннү хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхт төлөөлөгчийг, 2024 оны 67-р тогтоолоор Хүннү хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, орон тооны хязгаар баталсан. ЗГ-ын 2024 оны 114-р тогтоолоор Хүннү хотын хөгжлийн корпорац ХХК-г байгуулах шийдвэр гарч 2025 оны 3р сараас “Хотын газар хөгжүүлэлт, менежмент, бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, нийслэлийн 80%, Төв аймгийн 20%-ийн өмчийн оролцоотой “Хүннү хотын хөгжлийн корпорац” ХХК байгуулагдан ажиллаж байна.

Үр дүн гараагүй, 70 хувьтай 4 арга хэмжээ байна. Үүнд:

Арга хэмжээ 3.2.2. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн хэрэгжүүлж эхэлнэ.



Арга хэмжээ 3.2.4. Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.

Арга хэмжээ 8.1.8. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжинд алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.

Арга хэмжээ 8.1.10. Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээний 9 зорилт, 19 арга хэмжээний хэрэгжилт 2025 оны хагас жилийн байдлаар **88.4** хувьтай, **“үр дүн гарсан”** гэж дүгнэв.

Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд 2025.05.30-ны байдлаар орон нутагт 180 тэрбум төгрөгийг 1,559 зээлдэгч, мөн 362 зээлдэгч 42.1 тэрбум төгрөгийн 3 хувийн ипотекийн зээл авч, зээлийн батлан даалтын сангаар 111 зээлдэгч 2.33 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан. Ипотекийн 3 хувийн зээлийг нийт өссөн дүнгээр 4427 зээлдэгч 477 тэрбум төгрөгийн зээл авсан. Нийт 521.9 тэрбум төгрөгийг 4,163 зээлдэгчид олгосноор өссөн дүнгээр 52187 иргэнийг ипотекийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.

“Ипотекийн зээлийн орон нутгийн орон сууцны санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г ХББОС-ын сайд, Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгч, арилжааны банкууд, Зээлийн батлан даалтын сантай байгуулан 2025.03.20-ны өдөр эцэслэн баталсан. ЗГ-ын 2025.06.04-ний өдрийн хуралдаанаар Уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2024 оны цэвэр ашгаас нийт 480.2 тэрбум төгрөгийг хуримтлалын сангаар дамжуулан орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн байна.

Төвлөрлийг сааруулах, шинэ хот барьж байгуулах ажлын хүрээнд “Шинэ Зуунмод” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн инженерийн дэд бүтцийн барилга угсралтын ажлын хүрээнд цахилгаан хангамжийн ажил (“Хөндий” дэд станц, “Зуунмод” дэд станцын өргөтгөл, цахилгаан дамжуулах 15.7 км агаарын шугам), үерийн далан хамгаалалтын суваг (4.9 км), ус хангамж ажил (гадна усан хангамж 14 км, гүний худаг 5 ш, өргөлтийн насос станц 1 ш)-ыг хийж, 2024 онд ашиглалтад оруулсан.

Мөн Шинэ Хархорум хотыг байгуулах 189363 га газрыг Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор тогтоож тусгай хэрэгцээнд авсан. Хотыг байгуулах ажлын хүрээнд холбогдох нийт 16 ажлын даалгавар батлагдаж Хархорум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг Засгийн газрын 2025.04.09-ний өдрийн 165 дугаар тогтоолоор баталсан. Инженер хайгуул судалгааны ажлууд, холбогдох зураг төслийн ажлууд хийгдэж байна.



ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Бүх газар, хэлтэст зөвлөмж болгох нь:

1. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг олон улсын түвшинд хүргэж, шинэчлэх, агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд тусгагдсан, 70, 90 хувьтай бүрэн хэрэгжүүлж дуусгах 14 арга хэмжээг 2025 оны эцэс гэхэд хэрэгжилтийг бүрэн хангуулах;

3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжих хугацаа 2025 онд дуусч байгаа тул тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилго, зорилт, заалт бүрийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахыг зөвлөж байна.

Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохиуулалтын газарт:

1. Шинээр боловсруулах таван жилийн үндсэн чиглэлийн бодлого төлөвлөлтийн санал боловсруулах Ажлын хэсгийг цаглабарт хугацаанд байгуулж төлөвлөлтийг сайжруулах, суурь судалгаанд үндэслэх, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан оновчтой, зөв тодорхойлох, саналыг хугацаанд нь хүргүүлэх, үндсэн чиглэлийн эцсийн төслийг Ажлын хэсэгт /газруудад/ эргэн танилцуулдаг байх, эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй төсөл арга хэмжээг тэр даруй хариу хүргүүлж байх;

Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

2. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьж батлуулах ажлыг зохион байгуулах;

Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

3. “Барилгын цемент, арматур, хавтгай шил зэрэг үндсэн нэр төрлийн материалыг эх орны эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэх замаар импортыг бууруулж, бага өртөгтэй орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодит арга хэмжээг хэрэгжүүлэх;

Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газарт зөвлөмж болгох нь:

4. Инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд аймаг нийслэлийн нэгдсэн судалгаа гаргах, жил бүрийн хэрэгжсэн ажилтай уялдуулан мэдээллийн сангийн баяжуулалт хийх, төлөвлөлтийг сайжруулахад анхаарч ажиллах;

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ,
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР